



ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР
ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 07 өдөр

Дугаар А/48

Улаанбаатар хот

Сургалтад хамруулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 10 дахь заалт, Хөдөлмөрийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.2.9 дэх заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 3.27.1 дэх заалт, “Иргэний нисэхийн ерөнхий газрын 2023 оны төлбөртэй дотоод сургалтын төлөвлөгөө”-г тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Ай Си Ти Трэйнинг” ХХК-д 2023 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 05 дугаар сарын 13-ны өдрийн хооронд танхимаар зохион байгуулагдах “СНА сүлжээний болон CompTIA системийн сургалт”-д Холбоо, навигаци, ажиглалтын албаны Холбооны хэсгийн Өгөгдлийн холбооны тасгийн өгөгдлийн холбооны инженер Д.Ганбилэг, Ч.Бат-Оргил нарыг хамруулсугай.

2.Сургалтын төлбөрт 1,950,000 (нэг сая есөн зуун тавин мянга) төгрөгийг гарган зарцуулахыг Санхүү, эдийн засаг төлөвлөлтийн газар (Д.Пүрэв-Очир)-т зөвшөөрсүгэй.

3.Сургалтын үр дүнд хяналт тавихыг Холбоо, навигаци, ажиглалтын алба (Г.Баттөгс)-нд, сургалтад бүрэн хамрагдаж 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн дотор тус албанд тайлагнахыг суралцагч нар (Д.Ганбилэг, Ч.Бат-Оргил)-т тус тус даалгасугай.

4.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөцийн газар (Э.Нарантунгалаг)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН ҮҮРГИЙГ ХАВСРАН
ГҮЙЦЭТГЭГЧ

Н.БАТСАЙХАН



1723 01 0376